

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2021 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**  
(хагас жилийн байдлаар)

**2021 онд дэвшүүлсэн зорилт:**

- ✓ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж, авлигаас ангид төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиглэлээр бусдад сайн туршлага болохуйц олон талт арга хэмжээг санаачлан хэрэгжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргээ шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах.

№	Зорилго		Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж	Хэрэгжилт	Үнэл -гээ /хувь/
	Үйл ажиллагаа	№					
1.	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд нэр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх	ТАСЗ	Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ыг хянуулсны үндсэн дээр томилгоо хийж хэвшсэн бөгөөд 2021 онд 108 нийтийн албанд нэр дэвшиж буй албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хаягийг шинэчлэн сайжруулж байгаа тул ХАСУМ гэсэн цэсийг үүсгэн дүгнэлтийг байршуулна.	70
2.	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх	2	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болгох	Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх	ТАСЗ	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн 160 төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг хийж, олон нийтэд зарлах, бүртгэх бэлтгэл ажлыг хангасан. Цар тахлын улмаас сул орон тоог нөхөх, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулагдаагүй хүлээгдэж байгаа болно.	70
3.	Нийтийн албанд томилогдох албан	3	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, нээлттэй болгох	Албан тушаалтанд	ТАСЗ	Төрийн албаны тухай хуулийн 23, 26, 27, 28 дугаар зүйлд заасан шалгуур хангах тусгай	70



<p>тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх</p>		<p>шалгалт зохион байгуулагдаагүй ба Төрийн албаны зөвлөлийн 2020 оны зөвлөмжийн дагуу 14 сумын Засаг даргын Тамгын газар, агентлагуудад 75 албан хаагч түр томилогдсон байна.</p>
<p>Төрийн хаагчийн ёс зүйн зөрчилд шинжилгээ шалтгаан нехцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах</p>	<p>Байгууллагуудын ёс зүйн хорооны шийдвэрийн санг бүрдүүлсэн байх</p>	<p>Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх</p>	<p>TAC3</p>	<p>Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар батлан гаргасан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” батлах тухай 33 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 02 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлж, бодит үр дүнд хүргэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай тул нийт төрийн албан хаагчдад 16 заалт бүхий албан даалгавраар үүрэг чиглэл өгсөн. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын 99 ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн зөвлөлийн дүн, судалгааг нэгтгэн авч дүн шинжилгээ хийсэн.</p>
<p>4.</p>	<p>4</p>			<p>70</p>

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" –ын дагуу байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулаагүй 8 байгууллагад ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж батлах чиглэл өгсөн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/247 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу Замын-Үүд сумын ЗДТГ, Сайншанд сумын ЗДТГ, Эрдэнэ сумын ЗДТГ, Өргөн сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хяналт шалтгалтыг хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд 4 байгууллагын ёс зүйн зөвлөлд 5 өргөдөл ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдлийн утга, агуулгыг судлан илэрсэн зөрчилд тохирох ёс зүйн хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, ёс зүйн хариуцлагыг хүлээлгэсэн. Төрийн албан хаагчийн гаргаж байгаа ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн, багш нар харилцаа, хандлага, хүүхдүүдтэй зүй бус харилцсан зэрэг зөрчлүүд байна.

Сумдын Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил, харилцаа, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах утасыг ажиллуулж байна. Төрийн албан хаагчдтай төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, шударга ёсыг баримталж, хариуцлагатай ажиллах талаар "Ашиг сонирхлын зөрчилгүй-Авлигагүй хамт олон" уриалга, "Авлигаас ангид –Амлалтын дэвтэр", "Санамж бичиг" - зэргийг байгуулсан байна.



						Хөвсгөл сумын ЗДТГ-аас “Ёс зүйтэй төрийн албан хаагчдийг шалгаруулах уралдаан”-ыг төрийн албан хаагчдын дунд 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулж байна.					
5.	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	5	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх	ТЗУХ	2021 оны эхний 5 сарын байдлаар орон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 4225 өргөдөл ирснээс аймгийн Засаг түүний Тамгын газарт хандаж бичгээр 75, цахимаар болон утсаар 21 өргөдөл ирсний 96 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг зохих ёсоор өгсөн байна. Энэ хугацаанд сумдын Засаг дарга түүний Тамгын газарт хандаж нийт 1650 өргөдөл гомдол, ирсний 90 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгсөн бусад нь судлагдах шатандаа хугацаа болоогүй байна.	70				
6.	Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	6	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх	ТЗУХ Архивын тасаг	Эдгээр өргөдөл, гомдлоос албан тушаалтны үйл ажиллагаа, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хуулийн дагуу аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд шилжүүлэн хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шийдвэрлэсэн байна. Сумдын Засаг дарга нарт хандаж иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, ёс зүйтэй холбоотой 4 өргөдөл, гомдлыг тухайн шатандаа шийдвэрлэж хариуг өгсөн байна.	70				
7.	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан	7	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	Хуулийн үйлчлэлд хамаарах нийт	ХЭЗХ	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем “ERP”-ийг нэвтрүүлэн 14 сумдтай албан бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. 14 байгууллагыг тус системд бүртгэсэн бөгөөд 3 агентлаг дотоод үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.	70				



	<p>сэдвээр танхимын сургалтад 573, цахим сургалтад 120 гаруй албан хаагчдыг хамруулсан.</p>		<p>албан хаагчдын 90 хувь буюу 182 албан хаагчийг давтан сургасан байх</p>		<p>тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх</p>
<p>8.</p>	<p>Дорноговь аймгийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар 2347 удаа төрийн 74 төрлийн лавлагаа, мэдээллийг e-mongolia.mn нэгдсэн портал сайтаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>13 сумын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний нэгдсэн төвд байрлах операторын үйлчилгээгээр дамжуулан нэг дороос төрийн 74 төрлийн лавлагаа, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	<p>ТЗУХ</p>	<p>Төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайтыг боловсронгуй болгосон байх</p>	<p>Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>
<p>9.</p>	<p><b>Эрүүл мэндийн чиглэлийн тусгай зөвшөөрлийн талаар:</b></p> <p>2021 оны эхний хагас жилд нийт шинээр эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл хүссэн 4 төсөл хүлээн авч дэмжигдэж, орон нутгийн 5 шинжээчийг гэрээний үндсэн дээр нэгдсэн удирдлагаар ханган томилж, төслийн хэрэгцээ, ажлын байрны нөхцөл, халдвар хамгаалал, эрүүл ахуй, хүний нөөц, хангамж, санхүүгийн боломж зэрэг чиглэлээр үнэлгээ хийлгэж, дүгнэлтийг тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн, эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 төслийг дэмжиж тусгай зөвшөөрлийг 3 жилээр шинээр олгосон. 7 аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл, байршлыг өөрчилсөн. Эхний хагас жилд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдах 44 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан. Мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсаар тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомж, шийдвэрийг байршуулан, ил тод байдлыг хангаж, гомдол санал гаргаагүй.</p> <p><b>Согууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн</b></p>	<p>ХОХБТХ</p>	<p>Төрийн бус байгууллагад шилжүүлэх зөвшөөрлийг тодорхойлсон байх</p>	<p>Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх</p>	<p>Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх</p>

**хүрээнд:** Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын дагуу аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг тухай бүрд шийдвэрлэсэн. Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А- 272 дугаар тушаал “Норматив тогтоох тухай”-аар тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог тогтоосон. 2021 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 185 аж ахуйн нэгжийн 224 цэгт үйл ажиллагаа явуулж, хүн амын тоонд харьцуулан тогтоосон нормативаас хэтрээгүй болно.

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл сунгах 23, шинээр авах 7, байршил өөрчлөх 1, сэргээх 1, нийт 23 аж ахуйн нэгжийн хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусах хугацаа бүхий мэдээллийг [Domogovi.gov.mn](http://Domogovi.gov.mn) сайтад тогтмол байршуулан ажиллаж байна.

**Түгээмэл тархацтай ашиглалт малталын зөвшөөрлийн талаар:**

Аймгийн нутагт нийт ашигт малтмал болон түгээмэл тархацтай ашигт малталын 354 тусгай зөвшөөрөл газар нутгийн 9,7 хувийг эзлэж байгаа ба тусгай зөвшөөрлийг дотор нь ангилвал ашигт малталын ашиглалтын 203, түгээмэл тархацтай ашигт малталын ашиглалтын 5 нийт 208 ашиглалтын тусгай зөвшөөрөл, ашигт малталын хайгуулын 128, түгээмэл



10.	<p>Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох</p>	3	<p>Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах болсон байх</p>	ТЗУХ МХГ	<p>тархацтай хайгуулын 18 тусгай зөвшөөрөл нийт 146 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. 2021 онд ашиглалтын 7, хайгуулын 7 нийт 14 тусгай зөвшөөрөл олгогдсноос Хатанбулаг, Сайхандулаан, Улаанбадрах сумдын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар шинээр олгосон.</p> <p>Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуй нэгжийн дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр 52 аж ахуйн нэгж, 75 иргэнд хяналт шалгалтын явцад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.</p> <p>Мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас 5 сумын ЕБ-ын 11 сургууль, 12 цэцэрлэгийн 28 удирдах ажилтанд байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор "Шилэн хяналтын цахим систем"-д 2021 оны эрсдэлийн үнэлгээг бүртгэж, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтаар нэгдсэн цахим сан бүрдүүлэн ажиллаж байна. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтын ажил хийгдээгүй болно.</p>	70
11.	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах</p>	4	<p>ТББ, мэргэжлийн холбоо, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар 2 жил тутамд үнэлгээ хийлгэсэн байх</p>	ТЗУХ	<p>Сайхандулаан сумын Засаг даргын А/09 захирамжаар "Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг иргэдээр үнэлүүлэх журам"- батлан 6 дахь жилдээ хэрэгжүүлж, 2019 оны 5 дугаар сараас <a href="http://www.dosaikhandulaan.mn">www.dosaikhandulaan.mn</a> цахим программ шилжүүлснээр сумын төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг иргэд гар утаснаасаа болон интернет орчноос шууд үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлсэн. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид</p>	30



12.	Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	1	Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах	Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх	СТСХ ХОХБТХ ОНӨГ	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг сар бэлтгэж дараа сарын 5-ны дотор шилэн дансанд байршуулсан. Гадаадын зээл тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын явцын дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд аймгийн ЗДТГ-ын <a href="http://dogpogovi.gov.mn">dogpogovi.gov.mn</a> цахим хуудсаар дамжуулан эхний хагас жилд 9 удаа мэдээлсэн.	70
13.	Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	3	Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах	Орон нутгийн төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх нөхцөл бүрдсэн байх	СТСХ	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор аймгийн 2021 оны төсвийн төсөл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээний төсөлд 9485 иргэний саналыг цахимаар авч, эрэмбэлэн нэгтгэж, хамгийн их санал авсан ажил арга хэмжээг төсвийн төсөлд тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.	70
14.		4	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын <a href="http://www.iltod.mn">www.iltod.mn</a> <a href="http://www.shilendans.com">www.shilendans.com</a> цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх	Цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах мэдээллийг хүргэж хэвшсэн байх	СТСХ	Аймгийн 2021 оны төсвийн төслийг Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны <a href="http://www.iltod.mn">www.iltod.mn</a> , <a href="http://www.shilendans.com">www.shilendans.com</a> цахим хуудаст байршуулсан. Мөн аймгийн ЗДТГ-ын <a href="http://dogpogovi.gov.mn">dogpogovi.gov.mn</a> цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийг ил тод, нээлттэй мэдээлсэн.	70
15.	Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах	5	Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Журмыг батлуулж, хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлсэн байх	СТСХ СХАА	Аймгийн СХАА-наас 2021 оны эхний хагас жилд 13 төсөвт байгууллага, 14 тусгай сан, 2 ОНӨ-ийн ХХК нийт 29 байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, шалгалтаар 279,9 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, орон нутгийн төсөвт 163,0 сая төгрөгийн, тухайн байгууллагад 116,9 сая төгрөгийн 94 акт, хугацаатай албан шаардлага 10-ийг бичсэн. Нийт тогтоогдсон актыг төлбөрийн 69,7 сая төгрөгийг барагдуулж, 210,2 сая төгрөгийн	70



16.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг бүрдүүлэлт, тайлагналтыг тогтолцоог боловсронгуй болгох	1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хянах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг цаг хугацаанд нь цахим системд оруулах	ОНӨГ	Сумд, агентлагын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт сайжирч, зөрчил багассан байх, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг цахим системд цаг хугацаанд оруулж хэвших	үлдэгдэлтэй ба үүнээс төлөгдөх хугацаа нь болоогүй 186.2 сая төгрөг байна.  Дорноговь аймгийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 43,7 тэрбум төгрөгийн 52 төсөл арга хэмжээ тусгагдсаны дагуу 43 төсөл арга, хэмжээг цахимаар зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж үнэлгээний хорооны гишүүдийн 130 мэдэгдэл, тайлбарыг цахим системд оруулсан	70
17.	Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	2	Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх	ОНӨГ	Худалдан авах ажиллагааг 100 хувь хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж, зарлагдсан тендерийн урилга, гарсан үр дүнг тухай бүрт нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, байгууллагын мэдээллийн самбар болон www.shifendans.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудаст байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг тендер зарлагдсан өдөрт нь "Зууны мэдээ" сонинд нийтлүүлж худалдан авах ажиллагааны хэрэгжилт явцын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна. Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах зөвлөмж, чиглэлийг сумд, агентлагын хөрөнгө оруулалт хариуцсан албан тушаалтад өгч ажилласан.	70	
18.		3	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлжүүлэх тухай саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх	ОНӨГ	Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг зохион байгуулахад гарсан зөрчил дутагдалгүй тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлжүүлэх	70	



19.	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	1	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Хяналт тавих боломж бүрдсэн байх	ХЭЗХ	70	тухай саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх нөхцөл гараагүй болно. Хөгжлийн шийдэл ТББ, BEST хөтөлбөртэй хамтран төрийн 9 байгууллагын "Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдалд хийх нээлттэй байдлын үнэлгээ"-г 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулсан.
20.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	2	Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан байх	ХЭЗХ СТСХ	70	2021 онд Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор Ахмадын хороонд 70.4 сая төгрөг, Эмэгтэйчүүдийн зөвлөлд 8,0 сая төгрөг, Улаан загалмайн хороонд 5,0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын шийдвэрээр орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж, мэдээллийг шилэн дансанд байршуулсан.	
21.	Орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах	3	Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах	Олон нийтийн дэд зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байх	ХЭЗХ	-	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Авлигын эсрэг хууль, тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах, үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр "Дорноговь аймаг дахь Авлигаас урьдчилан сэргийлэх иргэний хяналтын зөвлөл"-ийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, аймгийн ИТХ-аас сар бүрийн урамшуулал, аймгийн Засаг даргаас албаны ерөө болон тоног төхөөрөмж, тавилгын асуудлыг иж бүрэн шийдвэрлэсэн. 2020 онд орон нутгаас урамшууллын асуудлыг шийдвэрлээгүй тул үйл ажиллагаа зогссон.
22.	Авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаар улирал тутамд мэдээллийг холбогдох байгууллагаас авч удирдлагыг мэдээллээр хангах, АТГ-т хүргүүлэх	4	Цаашид авах арга хэмжээний чиглэл, хандлагыг тодорхойлох боломж бүрдэнэ.	ХЭЗХ	70	Эрүүгийн хуулийн Авлигын эсрэг гэмт хэргэг /22.1-22.12/ аймгийн хэмжээнд 2021 онд 3 бүртгэгдэж, 1.7 хувиар өссөн байна.	



23.	Төрийн байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журам нь хүнд суртал чирэгдэл учруулж байгаа бол нягтлан үзэж хуульд нийцүүлнэ.	5	Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, дүрэм, журмыг хяналтад авах	Мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн байх	ХЭЗХ	Сумын Засаг даргаас батлан гаргасан 78 захиргааны актыг хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хяналтад авч, мэдээллийн санг үүсгэсэн.	30
24.	6	Төрийн албан хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл болон зөрчлийн судалгааг улирал бүр авч, дүн шинжилгээ хийх	Мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн байх	ТАСЗ ТЗУХ	Тайлант хугацаанд 4 байгууллагын ёс зүйн зөвлөлд 5 өргөдөл ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдлийн утга, агуулгыг судлан илэрсэн зөрчилд тохирох ёс зүйн хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, ёс зүйн хариуцлагыг хүлээлгэсэн. Төрийн албан хаагчийн гаргаж байгаа ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийхэд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн, багш нар харилцаа, хандлага, хүүхдүүдтэй зүй бус харилцсан зэрэг зөрчлүүд байна.	70	
25.	7	Авлига үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, өртөх ажил эрсдлийн үйлчилгээг тодорхойлж санал дүгнэлт гаргах	Төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэх шалгуур боловсруулж, мөрдүүлэх	Шалгуур үзүүлэлт батлагдсан байна.	ХЭЗХ	Сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг төрийн байгууллагуудыг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод, нээлттэй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийг хангах байдлаар болон шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, үр дүнд хүрэхүйц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглүүлж, арга зүйгээр хангаж ажиллах талаар сумдын эрх бүхий албан тушаалтнуудад чиглэлийг хүргүүлсэн. Төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж байна.	30
26.	1	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих	Суурь үндэслэн нийгмийн хор аюулыг таниулах, судалгаанд авлигын хор аюулыг таниулах.	Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн	ХЭЗХ	Авлигын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг бүхий л арга хэлбэрээр явуулах, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэх	70



	<p>телевшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах</p>	<p>өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх</p>	<p>зорилгоор Авлигатай тэмцэх газраас иргэдэд зориулан бүтээсэн богино хэмжээний видео, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгааны шторк, мэдээллийг цахим орчин дахь олон нийтийн сүлжээнд 57789 хүнд хүргэсэн.</p>
<p>27.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, сумын Иргэний танхим болон Эрх зүйн тусалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах</p>	<p>2</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх</p>	<p>Цар тахлын нөхцөл байдалтай уялдан арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.</p>
<p>28.</p>	<p>Авлигын эсрэг хууль, үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнах</p>	<p>3</p>	<p>Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах</p>	<p>“Төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр цахимаар зохион байгуулж, сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, Цэцэрлэгийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч гэсэн 120 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Сургалтаар Авлига, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэрэг, зөрчил, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх, ажлын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх талаар болон Гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөлтийг хийхэд анхаарах асуудал, Байгууллагын Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөлтийг хийхэд анхаарах зарим асуудал, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргахад анхаарах зарим асуудал зэрэг сэдвүүдээр орсон.</p> <p>Мөн сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг</p>



29.		4	<p>Авлигаас сэргийлэх, гэгээрүүлэх нэгдсэн боловсруулж, үе шаттай байгуулах</p> <p>урьдчилан соён сургалтын төлөвлөгөө сургалтыг зохион байгуулах</p>	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх системтэй мэдлэг олгосон байна.</p>	<p>ХЭЗХ Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар</p>	<p>терийн байгууллагуудыг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод, нээлттэй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар терийн байгууллагад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийг хангах байдлаар болон шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, үр дүнд хүрэхүйц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглүүлж, арга зүйгээр хангаж ажиллах талаар сумдын эрх бүхий албан тушаалтнуудад чиглэлийг хүргүүлсэн.</p>
30.	<p>Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	5	<p>“Авлигаас ангид сайн засаглалын санаачилга-2021” уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулах</p>	<p>Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдал хангагдана.</p>	<p>ХЭЗХ</p>	<p>“Авлигаас ангид сайн засаглалын сайн санаачилга-2021” уралдааныг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны хооронд 2 сарын аяныг Боловсрол, Эрүүл мэнд, Соёл, нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулахаар төлөвлөсөн. Даланжаргалан сумын ЗДТГ-аас төсөвт байгууллагуудын дунд “МЭДЬЕ, ХЭВШБЕ, ЭРХЭМЛБЕ” уралдааныг зарлаж</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Авилга гэж юу</li> <li>✓ Иргэн таны мэдлэгт</li> <li>✓ Авлигатай тэмцэхэд таны оролцоо чухал</li> <li>✓ Хүнд суртал гэж юу вэ?</li> <li>✓ Авлига ямар хор хохиролтой вэ</li> <li>✓ Иргэн та авлигатай тэмцэж чадна</li> <li>✓ Хуулиа судалъя, хуулиа дээдлэе, хуулиа эрхэмлэе</li> </ul>



						<p>✓ Нэр төр бол гадаад хүн чанар, хүн чанар бол дотоод нэр төр</p> <p>✓ Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах</p> <p>✓ Иргэн бүр эрхээ эдлэгч, үүргээ биелүүлэгч байя” зэргээр тус бүр цахим хичээл, шторк бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулж, 2470 иргэнд хүрсэн байна.</p>
31.	<p>Боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах</p>	8	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах</p>	<p>Сурагчдын нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр болон хэрэглэгдэхүүнийг боловсруулж туршсан байх</p>	<p>ХЭЗХ НХБХ БСУГ</p>	<p>Бага ангид “Хүн ба нийгэм”, “Хүн ба орчин”, “Иргэний боловсрол” “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар, Дунд ангид “Түүх”, “Нийгмийн ухаан”, “Иргэний боловсрол” “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа” болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар, ахлах ангид нийгмийн ухааны хичээлээр сурагчид “Хувь хүн ба нийгэм”, “Нийгмийн харилцаа, хувь хүн” “Хувь хүн ба соёл”, “Хүний эрх ба хууль” бүлэг сэдвээр зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох, хууль, эрх зүйн мэдлэг олгодог.</p> <p>2020-2021 оны хичээлийн жилд ЕБС-ийн 14629 суралцагч танхим болон цахимаар 126 цагийн хичээлийг судалж насныхаа онцлогод тохирсон шударга байх, авлигаас ангид байх талаарх мэдлэг ойлголтыг олж авсан.</p>
32.		9	<p>Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах</p>	<p>Хүүхэд, залуучуудын шударга зан чанар, ёс суртахууны үнэлэмж дээшилсэн байх</p>	<p>НХБХ БСУГ</p>	<p>Цар тахлын нөхцөл байдалтай уялдан хичээл, сургалтын үйл ажиллагаа зогсоонтой холбогдуулан “шударга ёс”-ны сэдэвт өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулагдаагүй.</p>
33.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл</p>	1	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл,</p>	<p>Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх</p>	<p>ХЭЗХ Төсвийн шууд захирагч,</p>	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаарх видео шторкыг 70</p>



	ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх		теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн (фейсбүүк, твиттер, youtube суваг) мөн лэд дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх		Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Дорноговь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 14 сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, орон нутгийн DTV, DSB хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр түгээн ажилласан.
34.		2	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Дэмжиж хамтран ажилласан байх Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	ХЭЗХ Төсвийн шууд захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Авлигатай тэмцэх газраас аян, арга хэмжээ зохион байгуулагдаагүй.  -
35.		3	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжилд 110" мэдээллийн самбар ажиллуулах	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх АТГ-аас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	ХЭЗХ Төсвийн шууд захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сард сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төлөвлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн ба шалгалтын чиглэлд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд нутгийн захиргааны болон төрийн байгууллага бүр мэдээллийн самбарыг ажиллуулж, шинэчлэлтийг тухай бүр хийж ажилласан байна.
36.	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-ын сургалтад хамруулах	1	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	ХЭЗХ Төсвийн шууд захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга,	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг Боловсрол, Эрүүл мэнд, нутгийн захиргааны болон төрийн тусгай чиг үүргийн албан хаагчдыг сургалтад хамруулах захиалгыг хүргүүлсэн.  70



				салбар ЭБАТ нар		
37.	2	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Төсвийн шууд захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга	"Төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр цахимаар зохион байгуулж, сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, Цэцэрлэгийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч гэсэн 120 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан. Сургалтаар Авлига, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэрэг, зөрчил, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх, ажлын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх талаар болон Гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөлтийг хийхэд анхаарах асуудал, Байгууллагын Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөлтийг хийхэд анхаарах зарим асуудал, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргахад анхаарах зарим асуудал зэрэг сэдвүүдээр орсон.	70
38.	3	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх Хамрагдсан хүүхэд, залуус, иргэдийн тоо	НХБХ БСУГ	Авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, нөлөөлөлийн ажлын хүрээнд сурагчдын дунд "Миний мэдэх шударга ёс" сэдэвт эссэ бичлэг, гар зургийн уралдааныг зохион байгуулж, 14 сурагчийн бүтээлийг шалгаруулсан. Авлига, ашиг сонирхлын зөрчил, шударга ёсны талаарх 4 удаагийн сургалтад ахлах ангийн 718 сурагчдыг хамруулсан.	30
39.	1	Авлигатай тэмцэх газраас зөвлөмж Мөрдөгчийн мэдэгдэл Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Төсвийн шууд захирагч	Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/13906 дугаар албан бичгийн дагуу Замын-Үүд сумын 2 дугаар сургуулийн захирал Т.Баттуяа нь хууль тогтоомжийг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу зохих хяналт шалгалтыг хийж, эргэн танилцуулах чиглэл ирүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2020 оны А/885	70



40.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх	1	Авлигын эсрэг болон төрийн байгууллага, хэвшлийн байгууллагаас гаргасан санаачилга, уриа аянд нэгдсэн байдал	Дэмжиж хамтран ажилласан байх	Төсвийн захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга	дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, 2021 оны 01 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох хариуг хүргүүлсэн. Хөгжлийн шийдэл ТББ, BEST хөтөлбөртэй хамтран “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж” сэдэвт хэлэлцүүлгийг 18 албан хаагчдын дунд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Орон нутгийн өмчийн газар, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл олгоход оролцдог төрийн албан хаагчдыг хамруулсан.	30
41.		2	Төрийн байгууллага, хэвийн хэвшлийн байгуулах хооронд аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	Үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байх	Төсвийн захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга	Аймгийн Засаг даргаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагатай байгуулах, хариуцлагын гэрээний төсөлд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгахаар бэлтгэж байна.	30
42.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдлийн үнэлгээг хийлгэх/	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	Төсвийн захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга	Цар тахлын нөхцөл байдалд иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан аймаг, сумын онцгой комиссоос олгох зөвшөөрлийг цахимаар өгөх боломжийг бүрдүүлэн, иргэдийн зорчих хөдөлгөөний бүртгэлийн Smart.dorlogovi.gov.mn цахим системийг ашиглалтад оруулан, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн ажиллаж байна.	70
43.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	1	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	Төсвийн захирагч, Сумдын ЗДТГ-ын дарга	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 14 сумын төсвийн эрх захирагч, орон нутгийн өмчит байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хуульд заасан хугацаанд байршуулах	70



44.			заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд, олон нийт үзэж танилцах боломжоор хангах			талаар цахимаар 2 удаа сургалт зохион байгуулсан. Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу 14 сумын 135 төсвийн байгууллага, аймгийн төвийн 14 байгууллага нийт 149 байгууллага оны эхний 5 сарын байдлаар 8775 мэдээллийг цахим хуудсанд байршуулахаас 8694 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн нь 99,07 хувь байна.
		1	Авлигатай тэмцэх газрын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж буй зарим эрх бүхий албан тушаалтнуудтай хамтран сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Эрх бүхий албан тушаалтнуудын хамтын ажиллагаа дээшилсэн байна.	ХЭЗХ	2021 онд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад 18 эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан.  70
45.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар АТГ-тай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	2	Орон нутгийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага дээшилнэ.	ХЭЗХ	Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сард сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төлөвлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн ба Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт болон төсөвт байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд нийтлэг зөрчил дутагдал илэрсэн. Мөн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга буюу эрх бүхий албан тушаалтнуудын 42.8 хувь нь шинээр томилогдсон байх тул Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар болон эрх бүхий албан тушаалтны хувьд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж, чиглэлийг 2021 оны 06 дугаар



						сарын 25-ны өдрийн 03/871 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.
46.	Авлигатай тэмцэх газраас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх талаар	1	Хууль бус орлого, хөрөнгийг илрүүлж, гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд АТТ-т шилжүүлэх	Дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлнэ.	ХЭЗХ Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сард сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төлөвлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээгээр Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Н.Тунгалаг нь сумын хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэсэн "Борхойн зам" ХХК руу ажлын гүйцэтгэлийг хянаж үзэлгүй 30,0 сая төгрөгийг илүү шилжүүлж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 14,9 сая төгрөгийг буцааж дансанд тушаасан боловч 16.1 сая төгрөгийг одоог хүртэл дансанд төвлөрүүлээгүй байсан тул Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн гэрээний 5.1.1 дэх заалтын дагуу хөдөлмөрийн гэрээг цуцалж, хууль хяналтын зохих байгууллагаар шалгуулахыг чиглэл болгосон.
47.		4	Орон нутгийн хэмжээнд томилгоотой холбоотой шийдвэрт судалгаа, дүн шинжилгээ хийж, тухайн салбарт гарч буй нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсч болзошгүй нөхцлийн талаар зөвлөмж, чиглэл өгөх	Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.	ХЭЗХ Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийн дагуу 05 дугаар сард сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төлөвлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн ба сумын Засаг даргаас батлан гаргасан боловсон хүчний 680 шийдвэрт хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгасан. Сумдын хэмжээнд Засаг даргын орлогч, багийн Засаг даргыг нэр дэвшүүлэх болон томилгоо хийхтэй холбогдуулан тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөж ажиллах талаар чиглэлийг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/871 тоот албан бичгээр хүргүүлсэн.
48.				Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангагдана.	ХЭЗХ Сумдын ЗДТГ-ын дарга,	2021 онд зөвлөмж ирээгүй болно.



		зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих		салбар ЭБАТ нар		
49.	2	Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэсэн тухай мэдээллийн сан үүсгэн ажиллах	АТГ-ын 2018.11.14-ний өдрийн А/123 дугаар тушаалын хэрэгжилт хангагдана.	ХЭЗХ Сумдын ЗДТГ-ын дарга, салбар ЭБАТ нар	Авлигатай тэмцэх газрын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Хариуцлага тооцуулах тухай" 05/1598 дүгээр албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Сахилгын шийтгэл хүлээлгэх тухай" Б/07 дугаар захирамжаар "Замын-Үүд нийтийн аж ахуй үйлчилгээ" ОНӨХХК-ийн захирал Ө.Нарантуяад албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл хүлээлгэн, 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 02/343 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хариуг хүргүүлсэн. Шийдвэрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлж, мэдээллийн санг үүсгэсэн.	70
Хэрэгжилтийн хувь					62.7%	

Тайлбар: Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөсөн нийтийг хамарсан сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй бөгөөд цахим орчин дахь олон нийтийг сүлжээг тулгуурлан зохион байгуулж байна.

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



ХЭРЭГЖИЛТИЙГ НЭПТГЭН ГАРГАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.САНСАРМАА